



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/631

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орж Нисэх буудлуудын удирдах газар шинээр байгуулагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын эргэлтийн болон үндсэн хөрөнгийн тооллого хийх комиссыг хавсралтаар баталсугай.

2. “Чингис хаан” Олон улсын нисэх буудал, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Холбоо, навигаци ажиглалтын алба, Газрын тусгай үйлчилгээний албанд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн тооллого хийх тооллогын комиссыг байгуулж, 2018 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тооллогыг чанартай сайн гүйцэтгэж, салбар хооронд шилжүүлэх, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн жагсаалтыг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Өмч хамгаалах байнгын зөвлөлд ирүүлэхийг тооллогын комисс болон алба, салбарын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эргэлтийн болон үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусган ажиллахыг алба, салбарын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудын хөрөнгийн тооллого, тооцооны ажлын явц үр дүнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах, холбогдон гарах зардлыг санхүүжүүлэн ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т даалгасугай.

ДАРГА



Л. БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 10 дугаар сарын 01 ний өдрийн
А/63! . . . дүгээр тушаалын хавсралт

Иргэний нисэхийн ерөнхий газрын эргэлтийн болон
үндсэн хөрөнгийн тооллого хийх комисс

Комиссын дарга:	Б.Ганхуяг	Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Наранчимэг	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нярав
Гишүүд:	Ч.Баяртөгс	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын нягтлан бодогч
	Ц.Энхбаяр	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны тооцооны нягтлан бодогч
	З.Ундаръяа	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны тооцооны нягтлан бодогч
	Ц.Оюун-Эрдэнэ	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нярав
	С.Чинзориг	Үйлчилгээ, аж ахуйн албаны Аж ахуйн тасгийн хангамжийн мэргэжилтэн

xxx xxx